

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ АНХДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны нэгдүгээр сарын 08-ны 14 цаг 06 минутад эхэлж, 15 цаг 12 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 06 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	УИХ-ын гишүүнээр 2000-2004 онд, 2004-2012 онд Ховд аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Г.Нямдавааг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 2000-2004 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон, 2004-2012 онд Ховд аймгийн Засаг даргын албан тушаалд томилогдон ажиллаж байсан Гэндэнжавын Нямдавааг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайдаар ажиллаж байсан Ц.Тувааныг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 2012-2014 онд Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайдаар томилогдон ажиллаж байсан Цэвэгдоржийн Тувааныг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
3	Ж.Хатанбаатар, Я.Ариунзул, С.Саран, Б.Ганцэцэг, П.Цэцгээ нарыг төрийн жинхэнэ албаны удирдах албан	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор

	тушаалын нөөцөөс хасах тухай	<p>батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.4 дэх заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2015 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн ХЭГ/06 тоот албан бичгийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын нөөцөд бүртгэгдсэн Жамбалын Хатанбаатарыг, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын нөөцөд бүртгэгдсэн Янгивын Ариунзул, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын нөөцөд бүртгэгдсэн Солонгын Саран, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын нөөцөд бүртгэгдсэн Баасанжавын Ганцэцэг, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 33 дугаар тогтоолоор Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын нөөцөд бүртгэгдсэн Пүрэвжавын Цэцгээ нарыг төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтаас хассанд тооцох</p> <p>2. Энэ тогтоолыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт болон иргэн Ж.Хатанбаатар, Я.Ариунзул, С.Саран, Б.Ганцэцэг, П.Цэцгээ нарт хүргүүлэхийг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	------------------------------	---

4	Зарим яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд нээлттэй зарлах тухай	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтын 2015 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн ХЭГ/22 тоот албан бичгээр Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын яам, Аж үйлдвэрийн яам, Зам, тээврийн яам, Уул уурхайн яам, Хөдөлмөрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэнд, спортын зэрэг яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг 2015 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2015 оны 2 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
5	Бусад асуудал	<p>Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн Дөрөв”-ын 4.4 дахь хэсгийг тус тус үндэслэж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Төрийн албаны институт /Сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний төв/-ийг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс татан буугдсанд тооцох 2. Төрийн албаны зөвлөлийн “Сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний төв байгуулах тухай” 2010 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 78 дугаар тогтоол, “Сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний

		<p>төвийн нэрийг өөрчлөх тухай” 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 66 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцох</p> <p>3. Төрийн албаны институтийн ажилтнуудтай ажил хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулахыг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ